

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны эрүүл мэндийн төвийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан**

Аудитын код: ХӨА-2025/151/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/184  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ ТОСГОНЫ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Г.НАРАНГЭРЭЛ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хатгал тосгоны эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,131,630.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 1,003,660.7 мянган төгрөгийг санхүүжилтийг авч 127,969.9 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 13,045.7 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчлийг илрүүлснээс 8,988.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,057.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өглөө.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Хатгал тосгоны эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 98.0 хувьтай дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>202,542,980.73</u></b>	<b><u>353,424,569.16</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3,967,869.35	637,132.66
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	3,967,869.35	637,132.66
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	3,967,869.35	637,132.66
31211	Төрийн сангийн харилцах	3,967,869.35	637,132.66
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	7,680,090.00	127,969,931.54
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	7,680,090.00	127,969,931.54
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	0.00	728,111.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	728,111.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	190,895,021.38	224,089,393.96
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	21,611,800.00	31,382,910.62
35130	Эм боох материал	21,611,800.00	31,382,910.62
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	151,433,221.38	171,356,483.34
35410	Бичиг хэргийн материал	1,906,000.00	942,000.00
35420	Аж ахуйн материал	131,937,993.38	143,710,550.34
35460	Хүнсний материал	3,634,228.00	1,381,933.00
35470	Бусад хангамжийн материал	13,955,000.00	25,322,000.00
35600	Мал амьтад	17,850,000.00	21,350,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>438,279,960.56</u></b>	<b><u>639,328,759.73</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	438,279,960.56	639,328,759.73
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	415,287,960.56	616,157,226.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	204,999,232.72	224,899,232.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(95,251,162.48)	(114,750,978.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,686,434.00	270,849,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(56,041,544.96)	(47,158,966.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	413,164,939.00	441,909,031.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(200,848,288.76)	(187,248,984.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,340,723.00	39,752,514.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,996,584.34)	(14,967,768.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,036,382.98	11,036,382.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,802,170.60)	(8,162,604.72)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	22,992,000.00	23,171,533.32
39301	Програм хангамж	1,265,000.00	1,817,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(429,000.00)	(801,466.68)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,156,000.00	22,156,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>640,822,941.29</u></b>	<b><u>992,753,328.89</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>14,309,072.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	14,309,072.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	14,309,072.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.00	14,309,072.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	14,309,072.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>640,822,941.29</u></b>	<b><u>978,444,256.89</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	640,822,941.29	978,444,256.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	380,890,939.00	380,890,939.00
51101	Өмч: - төрийн	380,890,939.00	380,890,939.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	151,606,591.02	489,227,906.62
51210	Өмнөх үеийн үр дүн	151,606,591.02	151,606,591.02
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	337,621,315.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,325,411.27	108,325,411.27

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<b>640,822,941.29</b>	<b>992,753,328.89</b>
---	--	-----------------------	-----------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>804,888,279.46</b>	<b>1,586,373,755.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>57,014,446.36</b>	<b>403,316,914.41</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	57,014,446.36	403,316,914.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,014,446.36	23,473,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	23,473,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,014,446.36	379,843,514.41
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>747,873,833.10</b>	<b>1,183,056,840.80</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	40,606,100.00	59,106,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,606,100.00	59,106,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	707,000,533.10	1,123,950,540.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	707,000,533.10	1,123,950,540.80
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>965,290,050.77</b>	<b>1,248,752,439.61</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>965,290,050.77</b>	<b>1,248,752,439.61</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	965,290,050.77	1,222,600,977.18
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	563,004,808.94	795,596,216.45
210101	Үндсэн цалин	320,318,735.04	488,133,493.31
210102	Нэмэгдэл	185,609,666.29	250,727,705.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,928,000.00	5,528,300.00
210104	Урамшуулал	46,543,725.61	51,206,718.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	67,868,934.07	86,854,900.00
210201	Тэтгэврийн даатгал	45,392,934.07	60,341,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,570,200.00	6,628,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,507,000.00	3,314,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,128,100.00	3,314,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,270,700.00	13,256,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,139,600.00	53,567,837.57
210301	Гэрэл, цахилгаан	5,800,844.71	9,321,837.57
210302	Түлш, халаалт	41,786,255.29	43,433,000.00
210303	Цэвэр, бохир ус	552,500.00	813,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	51,427,260.00	37,834,460.00
210401	Бичиг хэрэг	5,032,200.00	3,199,900.00
210402	Тээвэр, шатахуун	19,315,565.00	22,755,579.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,465,000.00	3,530,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	485,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,011,200.00	7,863,981.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	83,539,245.71	91,957,955.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,944,728.71	76,052,795.86
210502	Хоол, хүнс	13,594,517.00	15,905,160.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,783,000.00	10,173,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	4,307,500.00
210604	Урсгал засвар	6,783,000.00	5,865,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,900,000.00	5,099,000.00
210702	Дотоод албан томилолт	1,900,000.00	5,099,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,371,120.00	3,716,721.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	850,000.00	1,298,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,602,000.00	1,152,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	249,300.00	129,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,020.00	165,859.00
210807	Газрын төлбөр	0.00	66,462.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	408,800.00	904,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>139,256,082.05</b>	<b>137,800,886.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,877,750.00	11,761,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,378,332.05	126,039,386.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>26,151,462.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>22,980,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	22,980,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>3,171,462.43</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,171,462.43
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(160,401,771.31)</b>	<b>337,621,315.60</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(160,401,771.31)</b>	<b>337,621,315.60</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>740,193,743.10</b>	<b>1,086,240,399.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>23,473,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>23,473,400.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>23,473,400.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	23,473,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>740,193,743.10</b>	<b>1,062,766,999.26</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>40,606,100.00</b>	<b>59,106,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,606,100.00	59,106,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>699,320,443.10</b>	<b>1,003,660,699.26</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	699,320,443.10	1,003,660,699.26
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>769,758,928.01</b>	<b>1,081,887,673.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>769,758,928.01</b>	<b>1,081,887,673.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>769,758,928.01</b>	<b>1,058,907,673.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>563,004,808.94</b>	<b>783,585,304.45</b>
210101	Үндсэн цалин	320,318,735.04	476,122,581.31
210102	Нэмэгдэл	185,609,666.29	250,727,705.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,928,000.00	5,528,300.00
210104	Урамшуулал	46,543,725.61	51,206,718.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,868,934.07</b>	<b>86,854,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,392,934.07	60,341,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,570,200.00	6,628,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,507,000.00	3,314,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,128,100.00	3,314,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,270,700.00	13,256,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,606,100.00</b>	<b>51,934,837.57</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,800,844.71	9,321,837.57
210302	Түлш, халаалт	30,252,755.29	41,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	552,500.00	813,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,974,930.00</b>	<b>42,342,370.00</b>
210401	Бичиг хэрэг	0.00	2,229,800.00

/төгрөгөөр/

210402	Тээвэр, шатахуун	18,601,340.00	23,483,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,465,000.00	3,530,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	1,289,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,658,590.00	11,809,880.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,733,385.00</b>	<b>75,689,640.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,387,725.00	62,020,775.50
210502	Хоол, хүнс	11,345,660.00	13,668,865.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,015,000.00</b>	<b>8,473,300.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	2,830,000.00
210604	Урсгал засвар	7,015,000.00	5,643,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,900,000.00</b>	<b>4,913,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,900,000.00	4,913,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,878,020.00</b>	<b>3,722,821.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	850,000.00	1,298,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,602,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	249,300.00	129,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,020.00	165,859.00
210807	Газрын төлбөр	0.00	66,462.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	915,700.00	910,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,777,750.00</b>	<b>1,391,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,777,750.00	1,391,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>22,980,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>22,980,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	22,980,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(29,565,184.91)</b>	<b>4,352,725.74</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,846,500.00</b>	<b>7,683,462.43</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,846,500.00</b>	<b>7,683,462.43</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,846,500.00</b>	<b>4,512,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,846,500.00	4,512,000.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>3,171,462.43</b>
226001	Гадаад эх үүсвэрээр	0.00	3,171,462.43
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(7,846,500.00)</b>	<b>(7,683,462.43)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(37,411,684.91)</b>	<b>(3,330,736.69)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>41,379,554.26</b>	<b>3,967,869.35</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,967,869.35</b>	<b>637,132.66</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	380,890,939.00	108,325,411.27	312,008,362.33	801,224,712.60

Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(160,401,771.31)	(160,401,771.31)
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>380,890,939.00</b>	<b>108,325,411.27</b>	<b>151,606,591.02</b>	640,822,941.29
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>380,890,939.00</b>	<b>108,325,411.27</b>	<b>151,606,591.02</b>	640,822,941.29
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>380,890,939.00</b>	<b>108,325,411.27</b>	<b>151,606,591.02</b>	640,822,941.29
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	337,621,315.60	337,621,315.60
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>380,890,939.00</b>	<b>108,325,411.27</b>	<b>489,227,906.62</b>	978,444,256.89

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,199,128,800.00</b>	<b>1,030,464,835.95</b>	<b>85.93</b>	<b>168,663,964.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,199,128,800.00</b>	<b>1,030,464,835.95</b>	<b>85.93</b>	<b>168,663,964.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,069,020,800.00</b>	<b>1,007,484,835.95</b>	<b>94.24</b>	<b>61,535,964.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>810,643,300.00</b>	<b>783,585,304.45</b>	<b>96.66</b>	<b>27,057,995.55</b>
210101	Үндсэн цалин	533,655,000.00	476,122,581.31	89.22	57,532,418.69
210102	Нэмэгдэл	224,560,300.00	250,727,705.12	111.65	(26,167,405.12)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,451,500.00	5,528,300.00	160.17	(2,076,800.00)
210104	Урамшуулал	48,976,500.00	51,206,718.02	104.55	(2,230,218.02)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>100,578,500.00</b>	<b>86,854,900.00</b>	<b>86.36</b>	<b>13,723,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	71,513,400.00	60,341,800.00	84.38	11,171,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,266,300.00	6,628,000.00	91.22	638,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,633,100.00	3,314,400.00	91.23	318,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,633,100.00	3,314,400.00	91.23	318,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,532,600.00	13,256,300.00	91.22	1,276,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,800,500.00</b>	<b>42,342,370.00</b>	<b>98.93</b>	<b>458,130.00</b>
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	2,229,800.00	51.75	2,078,900.00
210402	Тээвэр, шатахуун	24,512,000.00	23,483,690.00	95.80	1,028,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,296,400.00	3,530,000.00	107.09	(233,600.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,308,700.00	1,289,000.00	29.92	3,019,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,374,700.00	11,809,880.00	185.26	(5,435,180.00)
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>75,694,200.00</b>	<b>75,689,640.50</b>	<b>99.99</b>	<b>4,559.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,822,000.00	62,020,775.50	100.32	(198,775.50)
210502	Хоол, хүнс	12,622,200.00	13,668,865.00	108.29	(1,046,665.00)
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,250,000.00	0.00	0.00	1,250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,124,700.00</b>	<b>8,985,300.00</b>	<b>35.76</b>	<b>16,139,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	4,512,000.00	75.20	1,488,000.00
210602	Тавилга	13,750,000.00	0.00	0.00	13,750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,124,700.00	2,830,000.00	68.61	1,294,700.00
210604	Урсгал засвар	1,250,000.00	1,643,300.00	131.46	(393,300.00)
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,500,000.00</b>	<b>4,913,000.00</b>	<b>89.33</b>	<b>587,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,500,000.00	4,913,000.00	89.33	587,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,273,000.00</b>	<b>3,722,821.00</b>	<b>51.19</b>	<b>3,550,179.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,133,600.00	1,298,800.00	31.42	2,834,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,152,000.00	76.80	348,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	129,000.00	51.60	121,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,000.00	165,859.00	89.65	19,141.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	0.00	0.00	200,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	66,462.00	73.85	23,538.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	914,400.00	910,700.00	99.60	3,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,406,600.00</b>	<b>1,391,500.00</b>	<b>98.93</b>	<b>15,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,406,600.00	1,391,500.00	98.93	15,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>130,108,000.00</b>	<b>22,980,000.00</b>	<b>17.66</b>	<b>107,128,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>130,108,000.00</b>	<b>22,980,000.00</b>	<b>17.66</b>	<b>107,128,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	130,108,000.00	22,980,000.00	17.66	107,128,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,199,128,800.00</b>	<b>1,027,134,099.26</b>	<b>85.66</b>	<b>171,994,700.74</b>
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>996,550,200.00</b>	<b>1,003,660,699.26</b>	<b>100.71</b>	<b>(7,110,499.26)</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	996,550,200.00	1,003,660,699.26	100.71	(7,110,499.26)
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>202,578,600.00</b>	<b>23,473,400.00</b>	<b>11.59</b>	<b>179,105,200.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,858,000.00	23,473,400.00	14.78	135,384,600.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	43,720,600.00	0.00		43,720,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	3,967,869.35		(3,967,869.35)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	637,132.66		(637,132.66)

#### Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>59,106,300.00</b>	<b>55,934,837.57</b>	<b>94.63</b>	<b>3,171,462.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>59,106,300.00</b>	<b>55,934,837.57</b>	<b>94.63</b>	<b>3,171,462.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>59,106,300.00</b>	<b>55,934,837.57</b>	<b>94.63</b>	<b>3,171,462.43</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>55,106,300.00</b>	<b>51,934,837.57</b>	<b>94.24</b>	<b>3,171,462.43</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,806,300.00	9,321,837.57	95.06	484,462.43
210302	Түлш, халаалт	41,800,000.00	41,800,000.00	100.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	813,000.00	23.23	2,687,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,000,000.00</b>	<b>4,000,000.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00	100.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>59,106,300.00</b>	<b>55,934,837.57</b>	<b>94.63</b>	<b>3,171,462.43</b>
<b>13</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>59,106,300.00</b>	<b>55,934,837.57</b>	<b>94.63</b>	<b>3,171,462.43</b>
132001	Орон нутгийн төсвөөс	59,106,300.00	55,934,837.57	94.63	3,171,462.43
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>3,000,000.00</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,000,000.00	0.00	0.00	3,000,000.00

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 13,045.7 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчлийг илрүүлснээс 8,988.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,057.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өглөө.

#### **3.1 Залруулсан алдаа**

##### ***Залруулсан алдаа:***

- Ашиглалтад тавьж олгосон 5,865.5 мянган төгрөгийн автомашины дугуй, сэлбэг хэрэгслэлийг зарлагадаагүй, бараа материалын үлдэгдэлд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх;” гэж заасантай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” баталамж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулга хийж, бараа материалын үлдэгдлийг бууруулан, тайлант үеийн зардалд бүртгэсэн.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах үүднээс жилийн эцэст шатахууны мөнгө шилжүүлж, биетээр байхгүй шатахууныг орлогод авсан, 12-р сарын шатахууны зарлагыг дутуу гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 заалт “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” баталамж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулга хийж, шатахууны зардалд 2,395.2 мянган төгрөгийг бүртгэж, 728.1 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,057.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11,406.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

###### **Илрүүлэлт:**

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, эмийн зардлыг оруулалгүй орхигдуулсан, тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.1 "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11 "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна." гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Тайлант оны төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах.

## **2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

### Илрүүлэлт:

2024 онд 1,145,907.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 21,597.0 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

## **3. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар**

### Илрүүлэлт:

Хатгал тосгоны захирагчийн 2024 оны А/90 дүгээр захирамжаар эрүүл мэндийн төвийн даргад, Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар нярав, нягтлан бодогч нарт зөвхөн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар 4,057.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

## **4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 33, зарлагын 7 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэр, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн нь “Шилэн дансны

тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,” заалт, 6 дугаар зүйлийн 6.1.”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:”, 6.4.”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**5. Ахмадын сангийн талаар**

**Илрүүлэлт:**

Хатгал тосгоны эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ашиглалтад тавьсан бараа материалыг зарлагадаагүй, үлдэгдэлд бүртгэлтэй байсан.	1	5,865.5			1	5,865.1	1	5,865.1		
Жилийн эцэст шатахууны мөнгө шилжүүлж, биетээр байхгүй шатахууныг орлогод авсан	1	3,123.2			1	3,123.2	1	3,123.2		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>89,88.7</b>			<b>2</b>	<b>89,88.7</b>	<b>2</b>	<b>89,88.7</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэж урамшуулсан байна.	1	4,057.0					1	4,057.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>4,057.0</b>					<b>1</b>	<b>4,057.0</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг тусгаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй.	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэ зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1						1	
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй байна.	1						1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>-</b>					<b>4</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			